



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2020 оны 08 сарын 17 өдөр

Дугаар А/23

Улаанбаатар хот

Журам, маягт, загвар батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид шагнал олгох журам"-ын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан" хүндэт тэмдгийн төрөл, түүнийг олгох эрх бүхий албан тушаалтны жагсаалт"-ын 6, 41 дэх хэсэг, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2004 оны "Үндэсний бичиг соёлыг дэлгэрүүлэгч шагнал бий болгох тухай" 199 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Боловсрол, шинжлэх ухааны салбарын албан хаагчид шагнал олгох журам"-ыг нэгдүгээр, "Засгийн газрын хүндэт тэмдэг"-ийн загварыг хоёрдугаар, Боловсрол, шинжлэх ухааны яамны "Хүндэт дэвтэр"-ийн загварыг гуравдугаар, "Боловсрол, шинжлэх ухааны яамны жуух бичиг"-ийн загварыг дөрөвдүгээр хавсралт ёсоор тус тус шинэчлэн баталсугай.

2. Журмыг баримтлан ажиллахыг аймаг, нийслэлийн боловсролын газар, шинжлэх ухааны байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /О.Хуягцогт/-т даалгасугай.


4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны "Журам, маягт, загвар шинэчлэн батлах тухай" А/828 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Л.ЦЭДЭВСҮРЭН

Боловсрол, шинжлэх ухааны
сайдын 2020 оны 08 дугаар
сарын 17-ны өдрийн 17/23 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЛБАРЫН АЛБАН ХААГЧИД ШАГНАЛ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Боловсрол, шинжлэх ухааны салбарыг хөгжүүлэх үйлсэд бодитой хувь нэмэр оруулсан, онцгой амжилт гаргасан салбарын албан хаагч, Монгол улсын болон гадаадын иргэнийг Засгийн газрын /цаашид “салбарын шагнал” гэх/ болон Боловсрол, шинжлэх ухааны яамны шагнал /цаашид “яамны шагнал” гэх/-д нэр дэвшүүлэх, шагнаж урамшуулахад энэхүү журмыг мөрдөнө.

Хоёр. Шагналын ангилал

2.1. Засгийн газрын шагнал нь дор дурдсан ангилалтай байна. Үүнд:

2.1.1. “Боловсролын тэргүүний ажилтан” хүндэт тэмдэг;

2.1.2. “Шинжлэх ухааны тэргүүний ажилтан” хүндэт тэмдэг;

2.2. Боловсрол, шинжлэх ухааны яамны шагнал нь дор дурдсан ангилалтай байна.

Үүнд:

2.2.1. Яамны “Хүндэт дэвтэр”-т бичих;

2.2.2. Яамны “Жуух бичиг”;

2.2.3. “Үндэсний бичиг соёлыг дэлгэрүүлэгч” тэмдэг, үнэмлэх;

Гурав. Шагнал олгох нөхцөл

3.1. Боловсрол, шинжлэх ухааны салбарыг хөгжүүлэх үйлсэд бодитой хувь нэмэр оруулан, ажлын амжилт, бүтээл нь өмнөх түвшнээс ахиж, хамт олон, мэргэжлийн байгууллагаар үнэлэгдсэн албан хаагчид шагналыг яам, Засгийн газрын гэсэн дарааллаар олгоно.

3.2. Яамны шагналыг боловсрол, шинжлэх ухааны салбарт хамт олноо манлайлан 9-өөс доошгүй жил ажилласан албан хаагчид, Засгийн газрын шагналыг салбарт 12-оос доошгүй жил ажилласан, мэргэшлийн өндөр ур чадвартай, энэхүү журмын 3.1, 3.8-д заасан шаардлагыг тус тус хангасан албан хаагчид олгоно.

3.3. Шагналыг Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид шагнал олгох журам"-ын 2.5-д зааснаас гадна тухайн салбар байгууллагын 50 болон түүнээс дээш 10 жилийн давтамжтай тэгш ой, салбарын дор дурдсан тэмдэглэлт өдрийг тохиолдуулан тус тус олгоно. Үүнд:

3.3.1. "Боловсролын тэргүүний ажилтан" хүндэт тэмдгээр Дэлхийн /Монголын/ багш нарын өдөр; (жил бүрийн 10 дугаар сарын 05-ны өдөр);

3.3.2. "Шинжлэх ухааны тэргүүний ажилтан" хүндэт тэмдгээр Шинжлэх ухааны ажилтны өдөр (жил бүрийн 11 дүгээр сарын 4 дүгээр долоо хоногийн Ням гараг);

3.3.3. "Үндэсний бичиг соёлыг дэлгэрүүлэгч" тэмдгээр Үндэсний бичиг үсгийн баяр (жил бүрийн 5 дугаар сарын эхний Ням гараг);

3.4. Салбарын шагналаар шагнуулахаар нэр дэвшүүлэгч анхан шатны /нэр дэвшигчийг ажиллаж байгаа байгууллага, ахмад настан бол үндсэн байгууллага, төрийн бус гэх мэт/ байгууллага дор дурдсан баримт бичгийг баяр, тэмдэглэлт өдрөөс 45-аас доошгүй хоногийн өмнө журмын 3.5-д заасан байгууллагад гаргана. Шагналд нэр дэвшүүлэхдээ өмнө шагнагдсан шагналаас хойш 3-аас доошгүй жил тухайн салбартаа тогтвортой ажиллаж, ажлын амжилт бүтээл нь өмнөх түвшнээс өссөн эсэхийг харгалзана.

3.4.1. Шагнуулах тухай хүсэлт гаргасан байгууллагын албан бичиг;

3.4.2. Хамт олны хурлын тэмдэглэл;

3.4.3. Ажил байдлын дэлгэрэнгүй тодорхойлолт, бүтээлийн жагсаалт;

3.4.4. Батлагдсан загварын дагуу танилцуулга /цээж зураг, гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажсан/ анкет;

3.4.5. Яамны болон бусад шагналаар шагнагдсан бол тэдгээрийг гэрчлэх үнэмлэхийн хуулбар;

3.4.6. "Шинжлэх ухааны тэргүүний ажилтан" шагналд нэр дэвшигч нь бүтээлийн жагсаалт болон патент, ашигтай загварын гэрчилгээ, докторын зэрэг хамгаалуулсныг нотлох баримт;

3.5. Шагналд нэр дэвшүүлэгч анхан шатны байгууллага нь доор дурдсан холбогдох дээд байгууллагад уламжилна.

3.5.1. Яамны "Жуух бичиг", "Үндэсний бичиг соёлыг дэлгэрүүлэгч" тэмдэг, "Боловсролын тэргүүний ажилтан" шагналаар шагнуулахаар тодорхойлсон анхан шатны байгууллага нь нэр дэвшигчийн баримт бичгийг харьяа нутаг дэвсгэрийн боловсролын газар /аймаг, нийслэлийн боловсролын газар, их дээд сургууль бол Их, дээд сургуулиудын консорциум/-д;

3.5.2. "Шинжлэх ухааны тэргүүний ажилтан" шагналаар шагнуулахаар тодорхойлсон анхан шатны байгууллага нь нэр дэвшигчийн баримт бичгийг яамны шинжлэх ухааны бодлогын асуудал хариуцсан нэгжид;

Журмын 3.5-д заасан байгууллага нь шагналд нэр дэвшигчийн мэдээллийг баяр, тэмдэглэлт өдрөөс 30-аас доошгүй хоногийн өмнө боловсролын салбарын мэдээллийн

систем (www.esis.edu.mn)-д цахим хэлбэрээр мэдүүлэн, журмын 3.4-т заасан баримт бичгийг архивын түр хадгалах нэгж үүсгэн хадгална. Шагналын системийн цонхны дээд хэсэгт байрлах Эксел файл /дүрс/-ыг сонгох замаар нэр дэвшигчийн овог, нэр, регистрийн дугаар, тодорхойлсон шагналын жагсаалтыг хэвлэн авч, яаманд хандсан албан бичигт хавсарган ирүүлнэ.

3.6. Монгол Улсын Засгийн газрын шагналаар шагнахад энэхүү журмын 3.1, 3.2 болон дараах шаардлагыг нэгэн зэрэг хангасан байдлыг харгалзан үзнэ.

3.6.1. “Боловсролын тэргүүний ажилтан” (БТА) хүндэт тэмдгээр:

а. Ажил мэргэжлийн ур чадвар, мэргэшлийн түвшин нь сүүлийн жилүүдэд тогтвортой өссөн үзүүлэлттэй, багш, ажилтны дунд зохиогддог Улсын чанартай уралдаан, тэмцээнд эхний 3 байрт шалгарсан багш;

б. Тэргүүн туршлагаа аймаг, нийслэлийн хэмжээнд амжилттай түгээн дэлгэрүүлсэн нь холбогдох дээд шатны байгууллага /Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, Нийслэлийн боловсролын газар, аймгийн Боловсролын газар/-ын тодорхойлолтоор баталгаажсан багш, боловсролын салбарын удирдах ажилтан;

3.6.2 “Шинжлэх ухааны тэргүүний ажилтан” (ШУТА) хүндэт тэмдгээр:

а. Эрдэм шинжилгээний бүтээл нь олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөж, олны хүртээл болсон зэргээр шинжлэх ухааны хөгжилд бодитой хувь нэмэр оруулсан эрдэмтэн, судлаач;

б. Шинжлэх ухааны салбарын мэргэжлийн хүний нөөцийг бэлтгэхэд зохих хувь нэмэр оруулсан, 3 болон түүнээс дээш судлаачийн эрдмийн ажлыг удирдаж, докторын зэрэг хамгаалуулсан их дээд сургуулийн эрдэмтэн багш, судлаач;

в. Шинэ бүтээл, оновчтой санаачилга гарган улс эх орны өмнө тулгамдсан асуудлыг шинжлэх ухаан, технологийн ололтод түшиглэн шийдсэн инженер, зохион бүтээгч, эрдэмтэн судлаач;

г. Монгол Улсын шинжлэх ухааны салбарын хөгжил, салбарын гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулсан гадаадын иргэн;

3.6.3 “Хүндэт дэвтэр”-т бичигдэх:

Сайдын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн боловсрол, шинжлэх ухааны салбарыг хөгжүүлэх үйлсэд онцгой хувь нэмэр оруулсан тухайн салбар, яамны хувьд хамгийн хүндтэй эрхэм хүн;

3.6.4 “Үндэсний бичиг соёлыг дэлгэрүүлэгч” (ҮБСД) тэмдгээр:

Бичиг үсгийн үнэт дурсгал, Монгол бичгийг дээдлэх, түгээн дэлгэрүүлэх, сурталчлан таниулах үйлсэд амжилт гаргаж, үндэсний бичгээр улсын хэмжээнд зохион

байгуулагдсан уралдаан тэмцээнд эхний байрт шалгарсан, онцгой бүтээл гаргасан багш, судлаач, бичиг соёлын зүтгэлтэн, иргэн;

Дөрөв. Шагналыг шийдвэрлэх, олгох

4.1. Яамны шагналын асуудал хариуцсан албан хаагч нь энэ журмын шаардлагад нийцсэн баримт бичгийг шагналын комиссоор хэлэлцүүлнэ. Шагналын комиссын даргаар Төрийн захиргааны асуудал эрхэлсэн нэгжийн дарга, комиссын гишүүнээр Дээд, Бага, дунд, Сургуулийн өмнөх боловсролын асуудал хариуцсан нэгжийн дарга нар, нарийн бичгийн даргаар шагналын асуудал хариуцсан мэргэжилтэн байна. Шинжлэх ухааны асуудал хариуцсан нэгжийн дарга болон тус салбарын хүний нөөц хариуцсан мэргэжилтэн нь зөвхөн Шинжлэх ухааны ажилтны өдрийг угтсан шагналыг шийдвэрлэх комиссын бүрэлдэхүүнд орж ажиллана.

4.2. Шагналын баримт бичгийг хугацаа хоцруулсан, нэр дэвшигчийн тодорхойлолтыг дутуу эсвэл хуурамчаар бүрдүүлсэн, журмын шаардлагыг хангаагүй бол шагнал олгох асуудлыг хэлэлцэхгүй.

4.3. Шагналын комиссын гишүүдийн олонхийн санал авсан иргэнд сайдын шийдвэрээр шагнал олгож, шагналыг энэхүү журмын 3.5-д заасан байгууллагад хүлээлгэн өгнө.

Тав. Тэмдэг, үнэмлэхийг нөхөн олгох

5.1 Шагналын тэмдэг, үнэмлэхийг үрэгдүүлсний улмаас нөхөн авах тохиолдолд дор дурдсан баримт бичгийг бүрдүүлэн яаманд ирүүлнэ.

5.1.1. Нөхөн олгохыг хүссэн өргөдөл

5.1.2. Иргэний үнэмлэхийн хуулбар

5.1.3. Шагналын үнэмлэхийн /Хэрэв үнэмлэх, жуух нь үрэгдсэн бол шагнасан тухай шийдвэрийн/ хуулбар

5.2 Энэ журмын 5.1-д заасан баримтыг үндэслэн нөхөн олгоход гарсан зардлыг хүсэлт гаргасан тал хариуцна. Онцгойлон хүндэтгэх /гал, усны аюул, төлбөрийн чадвар, Монгол Улсын гавьяат болон түүнээс дээш цолтой гэх мэт/ шалтгааны улмаас үнэ төлбөргүй олгож болно.

Зургаа. Бусад зүйл

6.1 Боловсрол, шинжлэх ухааны яамны албан хаагчид болон харьяа агентлаг, байгууллагын зүгээс Төрийн дээд одон, медаль, Хүндэт өргөмжлөлөөр шагнуулахаар ирүүлсэн тодорхойлолтыг судлан, дээд удирдлагад танилцуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигаар батлагдсан "Монгол Улсын цол хүртээх, одон, медалиар шагнах журам"-д заасны дагуу нэр дэвшүүлэн, өргөн мэдүүлнэ. Мөн журмын 9-д заасны дагуу аймаг, нийслэлийн засаг даргад санал хүргүүлж болно.

---oOo---

Боловсрол, шинжлэх
ухааны салбарын
шагналын журмын
хавсралт

ШАГНАЛД НЭР ДЭВШҮҮЛЭХ АЖИЛТНЫ АНКЕТ

1. Овог:
2. Нэр:
3. Регистрийн дугаар:
4. Нас:
5. Хүйс:
6. Яс үндэс:
7. Бүртгэлтэй хаяг:
8. Ажлын газрын үндсэн захиргаа:
9. Боловсрол, мэргэжил эзэмшсэн байдал /он дарааллаар/

3x4 зураг

№	Төгссөн сургууль	Суралцсан хугацаа	Эзэмшсэн боловсрол, мэргэжил
1			
2			
3			

10. Ажил эрхэлсэн байдал /он дарааллаар/

№	Ажлын газрын нэр	Ажилласан хугацаа /он, сараар/	Эрхэлсэн ажил албан тушаал
1			
2			
3			
4			

11. Нийт ажилласан жил:

12. Үүнээс тухайн салбарт ажилласан жил:

13. Шагнагдаж байсан шагналууд /он цагийн дараалал баримтлан бичих бөгөөд Яамны бусад шагналаар шагнагдсан бол түүний **хуулбарыг заавал хавсаргана.**/

№	Шагналын нэр	Шагнал, үнэмлэхийн дугаар	Шагнагдсан он
1			

2			

14. Шагнуулах үндэслэл: /Товч, тодорхой бичнэ/

.....

.....

.....

.....

15. Шагнуулахад онцгойлон харгалзаж үзэх амжилт:

.....

.....

.....

16. Ямар шагналд нэр дэвшүүлж буй санал:

17. Хамт олны саналын хувь:

18. Шагналыг хүлээн авах /байгууллагын/ хариуцсан ажилтны нэр, утасны дугаар, мэйл хаяг:

.....,

..... /...../

дарга, захирал, эрхлэгч гарын үсэг, тамга гарын үсгийн тайлал

тэмдэг

---oOo---